



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/36

Цагаантолгой

Мод бэлтгэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.7, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 сарын 14-ний өдрийн 33 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн ойн сангаас 2022 онд цэвэрлэгээний ажлаар ойн санг гэрээгээр эзэмшигч Баянбүрд Тэлд Жалант нөхөрлөл цэвэрлэгээний ажлаар шинэс 30м/куб, хус 10м/куб, түлээнд шинэс 50м/куб, Алтансүмбэр нөхөрлөл цэвэрлэгээний ажлаар шинэс 40м/куб, хус 20м/куб, түлээ шинэс 200м/куб, Баян Баавгайт нөхөрлөл цэвэрлэгээний ажлаар шинэс 30м/куб, хус 40м/куб, түлээ шинэс 80м/куб, Хан хушаат нөхөрлөл цэвэрлэгээний ажлаар шинэс 30м/куб, түлээ 300м/куб хэмжээтэйгээр цэвэрлэгээний ажлаар бэлтгэхийг, Ойгоос арчилгааны огтлолын аргаар бэлтгэх шинэс 100м/куб, цэвэрлэгээний огтлолоор бэлтгэх шинэс 100м/куб хэмжээтэйгээр Мэргэжлийн байгууллагаар бэлтгүүлэхийг, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар бургас мод 50м/куб, хус- 30м/куб, Цэвэрлэгээний ажлаар 180м/куб хэмжээтэйгээр шаардлага хангасан иргэдэд олгохыг тус тус зөвшөөрсүгэй.

2. Сант сумын иргэдийн хэрэгцээний галын түлээ шинэс-3370 м/куб, улиангар 50м/куб модыг ойгоос мод бэлтгэх чадавхи бүхий иргэдэд өрхийн хэрэгцээний 8м/куб хэмжээгээр, бусдын түлээний хэрэгцээг орлого олох зориулалтаар мод бэлтгэж арилжаалдаг ажлыг модны захиалга, мод бэлтгэж худалдан борлуулах хүсэлт гаргасан иргэдээр гэрээгээр гүйцэтгүүлэхийг дэмжин ажилласугай.

3. Ойгоос бэлтгэгдэх хэрэглээний модны талбай тусгаарлах ажлыг сум дундын ойн ангиар хугацаа алдалгүй гүйцэтгүүлэх, ойн нөхөрлөлүүдийн бэлтгэх хэрэглээний модыг зохих хугацаанд нь бэлтгүүлэх, бэлтгэсэн модыг иргэдэд хуваарилах, галын түлээг хэрэгцээт иргэдэд олгох, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (А.Батдорж), Байгаль хамгаалагч (Ч.Төгсбаатар, Г. Ганжолоо) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.


С.ШИЖИРБААТАР

d/disk 2022 on zahiramj

2022.04.09

Боловсруулсан: Ч.Тогтоол
Хянасан: С.Шиндэрбаяр
Хувь: д.
Огноо: 2022.04.01